



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2026.05.25 № 27

Боловсролын салбарын багш,  
ажилчдын нийгмийн баталгааны талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд боловсролын салбарын багш, ажилчдын зүгээс ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэн дараах асуултыг тавьж байна.

1.Боловсролын салбарын багш, ажилчдыг орон сууцны хөнгөлөлттэй зээл, 6 хувийн хүүтэй ипотекийн зээлд хамруулах талаар баримталж буй бодлого, хэрэгжилт, нийслэл болон орон нутгийн багш, ажилчдын хамрагдалтын талаар;

2.Хөдөө орон нутагт багшийн дутагдлыг бууруулах, шинээр томилогдон очиж буй багш нарыг тогтвортой ажиллуулах, суурьшуулах зорилгоор дээрхээс гадна орон нутгийн онцлогт тохируулан багш нарт зориулсан орон сууц барих, ашиглалтад оруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, хамрагдсан аймаг, сум, багш нарын тоон мэдээлэл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, мөн өндөр насны тэтгэвэрт гартал тогтвортой ажилласан багшид тухайн орон сууцыг нь өмчлүүлэх боломжтой эсэх;

3.Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр багш мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж буй их, дээд сургуулийн болон орон нутгийн багш нарыг гадаадын сургалт, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамруулж байгаа эсэх, хамрагдсан багш нарын тоон мэдээлэл;

4.Сурагчдыг IELTS болон олон улсын түвшний англи хэлний шалгалтад бэлтгэх мэргэжлийн болон арга зүйн чадамжтай багш нарын хүрэлцээ, цаашид энэ талаар баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЭРДЭНЭБАТ